



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/795

Булган сум

**"Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн
эх бэлтгэхэд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн эх бэлтгэлийг "Ашин Булган" ХХК-тай гэрээ байгуулж хамтран ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т даалгасугай.

2.Дээрх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлж, хүлээн авахыг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Т.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

3.Гэрээний зардал 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Д.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011184